

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР  
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ  
ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ  
ТУХАЙ ГЭРЭЭ**

Энэхүү гэрээг нэг талаас Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Засаг дарга \цаашид “Засаг дарга” гэх\, нөгөө талаас ашигт малтмал тусгай зөвшөөрөл эзэмшигч “ЭС ЖИ ГРУПП” ХХК \цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх\ нар \цаашид хамтад нь “Талууд” гэх\ дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Энэхүү гэрээг Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Баян-Өлгий аймаг, Цэнгэл сумын 7-р багийн нутагт Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй Эс Жи Групп ХХК болон Нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбоотой харилцааг зохицуулна.

**Хоёр. Засаг даргын эрх, үүрэг**

- 2.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.
  - 2.1.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх ашиглах үйл ажиллагаа тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах
  - 2.1.2. Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч, саналыг нь авах,
  - 2.1.3. Энэхүү гэрээний хэрэгжилтэй холбоотой уулзалт , хэлэлцүүлэг зохион байгуулж, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр эн тухай иргэдэд мэдээлэх,
  - 2.1.4. Орон нутгийн иргэдэд энэхүү гэрээ болон гэрээтэй холбоотой хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр , бусад мэдээ мэдээллийн үнэн зөв өгөөгүй, эсвэл буруу мэдээлэл өгсөн тохиолдолд мэдээллийг өөрийн зардлаар задруулах
  - 2.1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод нээлтэй хэлбэрээр зохион байгуулах,
  - 2.1.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид хөдөлмөр эрхлэх хүсэлтэй орон нутгийн иргэдийн бүртгэх, зохион байгуулах , тусгай зөвшөөрөл эзэмшигчээс тавьсан шаардлагад нийцсэн иргэдийг санал болгох,
  - 2.1.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардлагатай байгаа ажлын байрны жагсаалтыг ирүүлсэн тохиолдолд ажлын байрны жагсаалт түүнд тавигдах шаардлагыг орон нутгийн иргэдэд хүртээмжтэй зарлах

2.1.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих

2.1.9. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагын хууль тогтоомжид нийцүүлээн шийдвэрлэж, зохих хариуг өгөх

### **Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг**

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Үйл ажиллагаагаа хэвийн тасралтгүй үйл явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх

3.1.2. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод нээлтэй хэлбэрээр нийтэд зарлах

3.1.3 Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийн хамруулах ажлыг зохион байгуулах

3.1.4. Нийт ажлын байрны 65-с доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшний сургалтад хамруулсны дээр ажиллуулах

3.1.5. Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг \ сум, дүүрэг\ийн иргэдэд тогтмол сар бүр мэдээлэл өгч байх

3.1.6. Бараа ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжиннд давуу эрх олгох

3.1.7. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах

3.1.8. Гамшигийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчиний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх

3.1.9. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь жил бүр сумын ЗДТГазраас зайлшгүй хийх жагсаалт бүхий ажлыг гэрээний хавсралтанд дурдсаны дагуу хийж гүйцэтгэнэ.

**Үүнд: 2022 оны хийх ажлүүд**

1. Сумын төвийн хогийн отвалыг овоолох, хашаажуулах ажилд 30.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

2. Байгалийн онц үзэгдэл гамшиг тохиолдсон үед машин, техник, хүн хүчиний тусламж үзүүлэх

3. Ажлын явц үр дүнгийн талаар сумын удирдалга, олон нийтэд мэдээллэж байх

4. Уурхай орчмын газрын хөрсийг хамгаалах эрүүл ахуйн шаардлага ханган ажиллах

### **Дөрөв. Гэрээний хариуцлага**

4.1. Талууд гэрээгээр хүлсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй

4.2. Гэрээний нэг талын гүйцэтгэхгүй байгаа үүргийг сайн дураар гүйцэтгэсэн тал нь тийнхүү бусад үүргийг гүйцэтгэхд шарсан бүх зардлаа буруутай талаас шаардах эрхтэй.

4.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарах мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

#### Долоо. Маргаан шийдвэрлэх

5.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зорчлийн эд зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдоо шүүхэд гаргаж болно.

#### Найм. Гэрээ хүчин төгөлдөр болох

6.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 1 чигжлийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

6.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

6.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруул болно. Гэрээнд оруулса нэмэлт өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

6.4. Гэрээг монгол хэл дээр З хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг англи хэл дээр үйлдэж болно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

НУТГИЙН ЗАХИРГААНЫ  
БАЙГУУЛЛАГЫГ ТОЛООЛЖ:

ЦЭНГЭЛ СҮМЫН ЗАСАГ ДАРГА  
Т.АЙТУГАН

ГАРЫН ҮСЭГ, ТАМГА

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
ЭЗЭМШИГЧИЙН ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Б.СОДНОМИЛ  
ЭС ЖИГРУУН  
ХЛК

ГАРЫН ҮСЭГ, ТАМГА

СҮМЫН ЗАСАГ ДАРГА

Т.АЙТУГАН

УУРХАЙН ДАРГА

ЗАХИРГААН ЗӨВШӨӨРСӨН

